

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/29/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: <a href="mailto:sarantuyab@audit.gov.mn">sarantuyab@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:naranbayarg@audit.gov.mn">naranbayarg@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:batsaikhants@audit.gov.mn">batsaikhants@audit.gov.mn</a></p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК Захирал: Ш.Ичинхорлоо Утас: 77270808 Цахим хаяг: <a href="mailto:nitsbalance@gmail.com">nitsbalance@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
<b>3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв .....</b>	<b>12</b>
3.9Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
<b>3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>13</b>
<b>3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....</b>	<b>14</b>
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4.1 Төлбөрийн акт.....	14
4.2Зөвлөмж .....	14

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгал



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2022.04.25 № 26  
тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ ХАЛХЫН  
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИГААНЫ ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
Б.САРАНТУЯА ТАНАА**

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,331,500.00</b>	<b>7,246,680.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>2,000,000.00</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.00</b>	<b>2,000,000.00</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>0.00</b>	<b>2,000,000.00</b>
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	0.00	2,000,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>600,000.00</b>	<b>0.00</b>
<b>34710</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	<b>600,000.00</b>	<b>0.00</b>
34714	Томилолтын урьдчилгаа	600,000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>4,731,500.00</b>	<b>5,246,680.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>4,731,500.00</b>	<b>5,246,680.00</b>
35410	Бичиг хэргийн материал	235,500.00	256,000.00
35420	Аж ахуйн материал	814,000.00	814,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,682,000.00	4,176,680.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>663,426,904.78</b>	<b>594,690,093.96</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>663,426,904.78</b>	<b>594,690,093.96</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>663,426,904.78</b>	<b>594,690,093.96</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	576,226,500.08	576,226,500.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-166,901,352.83	-195,712,677.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	111,554,354.80	13,657,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-108,032,931.20	-462,659.76
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	664,028,706.41	594,768,290.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	-427,111,471.57	-403,220,775.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,140,565.54	47,308,332.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,477,466.45	-37,874,415.74
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>668,758,404.78</b>	<b>601,936,773.96</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>668,758,404.78</b>	<b>601,936,773.96</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>668,758,404.78</b>	<b>601,936,773.96</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>668,758,404.78</b>	<b>589,136,773.96</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	753,137,286.96	668,758,404.78
51220	Тайлант үеийн үр дүн	-84,378,882.18	-79,621,630.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	12,800,000.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>668,758,404.78</b>	<b>601,936,773.96</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>178,952,986.00</b>	<b>170,335,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,159,500.00</b>	<b>4,700,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,159,500.00</b>	<b>4,700,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,200,000.00</b>	<b>4,700,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	1,700,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	3,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,959,500.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>175,793,486.00</b>	<b>165,635,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>162,729,200.00</b>	<b>155,435,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	162,729,200.00	155,435,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>13,064,286.00</b>	<b>10,200,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,350,000.00	10,200,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>263,331,868.18</b>	<b>249,956,630.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>263,331,868.18</b>	<b>249,956,630.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>232,295,797.06</b>	<b>224,805,369.52</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>86,774,841.60</b>	<b>95,442,567.75</b>
210101	Үндсэн цалин	75,249,030.60	92,396,031.75
210102	Нэмэгдэл	7,952,811.00	1,809,536.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,573,000.00	1,236,999.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,129,280.28</b>	<b>9,934,457.95</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,688,755.28	7,854,674.79
210202	Тэтгэмжийн даатгал	1,021,813.00	663,788.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	720,011.00	484,230.39
210204	Ажилгүйдлийн даатгал	139,374.00	83,496.67
210205	Эрүүл мэндийн даатгал	1,559,327.00	848,267.36
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,290,000.00</b>	<b>10,268,500.00</b>
210304	Байрны түрээс	10,290,000.00	10,268,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,194,744.17</b>	<b>14,288,133.00</b>
210401	Бичиг хэрэг	643,370.00	1,723,633.00
210402	Тээвэр, шатахуун	12,141,718.17	10,548,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,862,106.00	2,016,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	547,550.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,413,027.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	2,413,027.00	0.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>12,655,900.00</b>	<b>11,669,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	12,655,900.00	11,669,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,322,038.00</b>	<b>665,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,316,038.00	434,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	231,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>90,515,966.01</b>	<b>82,536,810.82</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	1,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	89,915,966.01	81,536,810.82
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,036,071.12</b>	<b>25,151,261.30</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>31,036,071.12</b>	<b>25,151,261.30</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,035,973.12	25,151,261.30
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	98.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-84,378,882.18</b>	<b>-79,621,630.82</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-84,378,882.18</b>	<b>-79,621,630.82</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	753,137,286.96	753,137,286.96
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	753,137,286.96	753,137,286.96
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-84,378,882.18	-84,378,882.18
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	668,758,404.78	668,758,404.78
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	668,758,404.78	668,758,404.78
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	668,758,404.78	668,758,404.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	12,800,000.00	0.00	12,800,000.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-79,621,630.82	-79,621,630.82
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0.00	12,800,000.00	589,136,773.96	601,936,773.96

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>176,993,486.00</b>	<b>170,335,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,200,000.00</b>	<b>4,700,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,200,000.00</b>	<b>4,700,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,200,000.00</b>	<b>4,700,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	1,700,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	3,000,000.00

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>175,793,486.00</b>	<b>165,635,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>162,729,200.00</b>	<b>155,435,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	162,729,200.00	155,435,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>13,064,286.00</b>	<b>10,200,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,350,000.00	10,200,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>176,993,486.00</b>	<b>168,335,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>176,993,486.00</b>	<b>168,335,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>145,957,414.88</b>	<b>143,183,738.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>86,707,425.60</b>	<b>93,107,187.00</b>
210101	Үндсэн цалин	65,526,674.16	68,845,779.00
210102	Нэмэгдэл	15,704,751.44	16,526,410.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,476,000.00	7,734,997.05
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,129,280.28</b>	<b>12,269,838.70</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,716,150.46	9,083,342.92
210202	Тэтгэмжийн даатгал	962,294.00	993,749.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	732,159.36	720,032.50
210204	Ажилгүйдлийн даатгал	142,362.89	131,691.75
210205	Эрүүл мэндийн даатгал	1,576,313.57	1,341,022.34
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,290,000.00</b>	<b>10,268,500.00</b>
210304	Байрны түрээс	10,290,000.00	10,268,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,460,428.00</b>	<b>14,803,313.00</b>
210401	Бичиг хэрэг	894,010.00	1,744,133.00
210402	Тээвэр, шатахуун	15,083,718.00	11,042,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,482,700.00	2,016,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	2,000,000.00	0.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,255,900.00</b>	<b>11,069,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	13,255,900.00	11,069,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,514,381.00</b>	<b>665,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,508,381.00	434,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	231,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>600,000.00</b>	<b>1,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	1,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,036,071.12</b>	<b>25,151,261.30</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>31,036,071.12</b>	<b>25,151,261.30</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,035,973.12	25,151,261.30
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>0.00</b>	<b>2,000,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>2,000,000.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	2,000,000.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>155,435,000.00</b>	<b>131,983,738.70</b>	<b>23,451,261.30</b>	<b>84.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>155,435,000.00</b>	<b>131,983,738.70</b>	<b>23,451,261.30</b>	<b>84.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>155,435,000.00</b>	<b>131,983,738.70</b>	<b>23,451,261.30</b>	<b>84.9</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>112,299,100.00</b>	<b>93,107,187.00</b>	<b>19,191,913.00</b>	<b>82.9</b>
210101	Үндсэн цалин	77,092,400.00	68,845,779.00	8,246,621.00	89.3
210102	Нэмэгдэл	23,401,900.00	16,526,410.95	6,875,489.05	70.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,804,800.00	7,734,997.05	4,069,802.95	65.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>15,360,000.00</b>	<b>12,269,838.70</b>	<b>3,090,161.30</b>	<b>79.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	10,815,900.00	9,083,342.92	1,732,557.08	84.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,136,000.00	993,749.19	142,250.81	87.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	908,800.00	720,032.50	188,767.50	79.2
210204	Ажилгүйдлийн даатгал	227,200.00	131,691.75	95,508.25	58.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,272,100.00	1,341,022.34	931,077.66	59.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,541,500.00</b>	<b>10,268,500.00</b>	<b>273,000.00</b>	<b>97.4</b>
210301	Гэрэл, цахилгаан	245,500.00	0.00	245,500.00	0.0
210304	Байрны түрээс	10,296,000.00	10,268,500.00	27,500.00	99.7
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,342,200.00</b>	<b>9,255,313.00</b>	<b>86,887.00</b>	<b>99.1</b>
210401	Бичиг хэрэг	1,005,600.00	918,713.00	86,887.00	91.4
210402	Тээвэр, шатахуун	6,320,300.00	6,320,300.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,300.00	2,016,300.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,128,000.00</b>	<b>6,417,000.00</b>	<b>711,000.00</b>	<b>90.0</b>
210702	Дотоод албан томилолт	7,128,000.00	6,417,000.00	711,000.00	90.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>764,200.00</b>	<b>665,900.00</b>	<b>98,300.00</b>	<b>87.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	514,200.00	434,900.00	79,300.00	84.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	231,000.00	19,000.00	92.4
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>155,435,000.00</b>	<b>131,983,738.70</b>	<b>19,451,261.30</b>	<b>87.5</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>155,435,000.00</b>	<b>131,283,738.70</b>	<b>21,151,261.30</b>	<b>86.4</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	155,435,000.00	130,283,738.70	21,151,261.30	86.4
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0.00</b>	<b>1,700,000.00</b>	<b>-1,700,000.00</b>	<b>0.0</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1,700,000.00	-1,700,000.00	0.0
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>21.00</b>	<b>21.00</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>		
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00		

<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>10.00</b>	<b>10.00</b>		
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00		
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>10,200,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,200,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>10,200,000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,548,000.00</b>
210401	Бичиг хэрэг	825,420.00
210402	Тээвэр, шатахуун	4,722,580.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,652,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,652,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>10,200,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,200,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,200,000.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Шилэн дансны тухай хуулийн болон цахим төлбөрийн баримтын системтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Эн Ай Ти Эс баланс аудит ХХК-ийн аудитор Г.Хүрэл гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Сав газрын хэмжээнд усны нөөцийн хомсдол, бохирдлоос хамгаалах боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд Говийн бүсийн эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах боломжит усны нөөцийг бий болгох, хүн ам, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилгоо биелүүлэх бүхий л хэрэгцээнд нь нийцсэн баталгаат усаар хангах, усны нөөцийг зүй зохистой ашиглах зорилт дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтүр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газрын захиргаа 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх баталсан төсвийн нийт зарлын хүлээгдэж буй гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд ерөнхий материаллаг байдлыг 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх баталсан төсвийн нийт зарлын хүлээгдэж буй гүйцэтгэл 249,956.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,499.5 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 1,750.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газрын захиргаа 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 66,821.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		2,000.0	2,000.0
Авлага	600.0		(600.0)
Бараа материал	4,731.5	5,246.8	515.3
Үндсэн хөрөнгө	663,426.9	594,690.0	(68,736.9)
Нийт хөрөнгө	668,758.4	601,936.7	(66,821.6)
Богино хугацаат өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	668,758.4	601,936.7	(66,821.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	668,758.4	601,936.7	(66,821.6)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагын ахмадын сангийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 600.0 мянган төгрөгийг тайлант онд барагдүүлж, шинээр авлага үүсгээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5,246.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 515.3 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 20.5 мянган төгрөг, шатах тослох материал 494.7 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 594,690.0 мянган төгрөг болж, 68,736.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 601,936.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 66,821.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хасах 66,821.6 мянган төгрөгийн үр дүнтэй гарсантай холбоотой байна. Тайлант оны үр дүн хасах дүнтэй гарсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 611 дугаар тогтоолоор хуримтлагдсан

элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг данснаас хасаж, ашиглах боломжтой зарим хөрөнгийг шинээр үнэлэн бүртгэж авсантай холбоотой.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого 2021 онд 170,335.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 14,330.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Үйл ажиллагааны орлого өмнөх 9.2 хувиар өссөн нь байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого 1,740.5 мянга, улсын төсвийн санхүүжилт 7,799.4 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 4,790.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үйл ажиллагааны зарлага 249,956.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 75,208.5 мянган төгрөг буюу 43.3 хувиар өссөн байна. Энэ нь цалин, НДШ-ийн зардал 29,043.5 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 3,768.5 мянга, хангамж, бараа материалын зардал 3,929.6 мянга, томилолтын зардал 2,3598.1 мянга, бараа, ажил үйлчилгээний зардал 13,837.3 мянга, урсгал шилжүүлгийн зардал 25,151.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 306,570.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 30,959.5 мянган төгрөгөөр бууруулан, 275,610.9 мянган төгрөгөөр баталсан байна. 2021 оны төсвийн тодотголоор улсын төсвийн санхүүжилтийг 120,175.9 мянган төгрөгөөр бууруулан, 155,435.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 155,435.0 мянган төгрөгийг баталснаас 131,983.7 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 23,451.2 мянган төгрөг буюу 15.1 хувиар хэмнэгдсэн нь Цалин хөлс, НДШ 22,282.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 273.0 мянга, хангамжийн материалын зардал 86.8 мянга, томилолт 711.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 9.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 10,200.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, хангамж бараа материалын зардалд 5,548.0 мянга, дотоод албан томилолтын зардалд 4,652.0 мянга, нийт 10,200.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газрын захиргааны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 81.8 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал, стандарт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй тул санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### **3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газрын захиргаа 2021 онд нийт 149 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод бүрэн байршуулахаас 146 мэдээллийг байршуулж, тухай бүр байршуулах 4 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Цахим төлбөрийн баримтын системийн шивэлтийн мэдээлэл нь Татварын ерөнхий хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Татварын ерөнхий хуулийн хэрэгжилт**

Тайлант онд 25,630.6 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс 1,956.5 мянган төгрөгийн төлбөрийг цахим төлбөрийн баримтын системд дутуу шивэгдсэнийг хянаж, баталгаажуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 54 дугаар албан бичгээр Итгэл үзүүлэхэд баримтлах журмын шаардлага хангаж байгаа тул Итгэл үзүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 3,055.7 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 142.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,956.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 957.2 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн бөгөөд залруулагдаагүй 3,055.7 мянган төгрөгийн алдаа зөрчил тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшинээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

### **4.1 Аудитын залруулга хийгдээгүй**

#### **4.2 Төлбөрийн акт**

4.2.1 Байгууллагын нэр бүхий 4 ажилтанд томилолтын мөнгийг 142.0 мянган төгрөгөөр илүү, 1 ажилтанд 70.0 мянган төгрөгөөр дутуу тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

#### **4.3 Албан шаардлага**

Шийдвэрлэсэн нь: Цахим төлбөрийн баримтын системд худалдан авалтын баримтыг тухай бүр шивүүлж, хяналт тавьж ажиллах албан шаардлага өгөх.

#### **4.4. Зөвлөмж**

##### **1. Төсвийн зарцуулалттай холбоотой**

###### 1.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын нягтлан бодогч холбогдох эрх бүхий байгууллагын батламж, гэрчилгээгүйгээр мэргэшсэн нягтлан бодогчийн нэмэгдлийг тооцон авч, 957.2 мянган

төгрөгийн үргүй зардал гаргасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:**

Тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж, төсвийг хэмнэлттэй үр ашигтай зарцуулж байх.

**2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой**

**2.1 Илрүүлэлт:**

1.1. Тайлант онд нийт 150 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод бүрэн байршуулахаас 146 мэдээллийг байршуулж, тухай бүр байршуулах 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрсэн байна. Энэ нь Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д: "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх гэсэнтэй заалтуудыг зөрчсөн,.

1.2. **2.2 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5.Аудитаар илэрсэн алдаа,зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитаар											
1	Байгууллагын нэр бүхий 4 ажилтанд томилолтын мөнгийг 142.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон	1	142.0			1	142.0				
2	Холбогдох эрх бүхий байгууллагын батламж, зөвшөөрөлгүйгээр мэргэсэн ня-богийн нэмэгдлийг үргүй зардал гаргасан	1	957.2							1	957.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
3	Тайлант онд нийт 150 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод бүрэн байршуулахаас 146 мэдээллийг байршуулж, тухай бүр байршуулах 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	0.0							1	0.0
4	Цахим төлбөрийн системд 1,956.5 мянган төгрөгийн худалдан авалтын баримт шивүүлээгүй	1	1,956.5					1	1,956.5		
Нийт дүн		4	3,055.7			1	142.0	1	1,956.5	2	957.2